



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 8/84

Улаанбаатар хот

Барилга байгууламж нийслэлийн
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сувилал сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны төв”-ийн 40,860,300.00 (дөчин сая найман зуун жаран мянга гурван зуу) төгрөгийн өртөг бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Нийслэлийн өмчид шинээр бүртгэгдэж байгаа барилгыг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725020393



۲۴۵۴ مصر و ۵۵ حسن (نصر) ۱۲۰۰ یمن

1725020190

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
01... дүгээр сарын 28-ны өдрийн
...484 дүгээр захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Шийдвэр	Бүртгэх үнэ /төгрөгөөр/
1	Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороонд байрлах "Сувилал сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны төв"-ийн барилга	Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо	1956	Нийслэлийн иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 82 дугаар тогтоол	40,860,000.00
	Нийслэлийн өмчид бүртгэх барилгын нийт дүн				40,860,000.00